

**“АЛБАДУУНА ХЭЛЭХ ТӨРИЙН ШАСТИР АРДЫГ ХҮЧДЭХ ДУСАЛ” ХЭМЭЭХ
НЭГЭН ГАР БИЧМЭЛ СУДРЫН ИРЭЛ ГАРЛЫН АСУУДАЛД**

Боржигин Чулуу

Товч агуулга: Өгүүлэлд юуны өмнө “Албадууна хэлэх төрийн шастир ардыг хүчдэх дусал” хэмээх нэгэн гар бичмэл эхийн хадгаламжийн байдал, хуудас хэмжээ, судрын нэрийн учир, жич агуулга хэлбэр зэрэг талаар танилцуулж, дараа нь тус гар бичмэл судар нь шунхан “Данжуур” дахь үзэмчний Цэвдэн бэйлийн хошууны гүүш Лувсанданзаны орчуулсан “Ардыг тэжээхүй дусал нэрт төрийн шастир”-ийн орчуулгад суурилан найруулсан бөгөөд бас зохих зарчмын дагуу засан өөрчилсөн онцлогтой гэж үзэв. Үүний суурин дээр тус сударнь монгол оронд дэлгэрсэн “Рашааны дусал”-ын олон эхүүдийн дотор нэгэн бие даасан эхэд тоочигдох ёстой гэх үзэлтийг дэвшүүлжээ.

Түлхүүр үг: “хүчдэх дусал”, Лувсанданзаны орчуулга, харьцаа холбоо

Энэтхэгээс үүсэлтэй ном ертөнцийн хос ёсны сургаал “Ардыг тэжээхүй дусал нэрт төрийн шастир” (эрдэм шинжилгээнд “Рашааны дусал” гэдэг) нь Энэтхэг уламжлалын бусад сургаал шүлгүүдээс илүүтэйгээр монгол оронд уламжлагдан дэлгэрсэн билээ. Олдож буй эх бичгүүдээс үзэхэд, “Рашааны дусал” нь анх XVIII зууны дундаж үед шунхан “Данжуур”-аар дамжин монгол хэлэнд орчуулагдсан төлөвтэй. Үүнээс бусад “Рашааны дусал”-ын монгол орчуулгууд гэвэл, Агваандампилийн орчуулга (1758 он), Цахар гэвшийн орчуулга (1779 он), Д.Галсанжамбын орчуулга (1868 он), Номтын Ринчений орчуулга (1895 он) зэрэг байдаг. Эдгээр таван зүйлийн орчуулгаас гадна халимагт “Рашаан номын тууж” ба “Онохуй шастир” хэмээх нэр бүхий “Рашааны дусал”-ын орчуулга бий гэж эрдэмтэн Б.Я.Владимирцов мэдээлсэн (Рашааны, 1964:26) боловч тэр нь хараахан судалгааны эргэлтэд орж чадаагүй байсаар юм. Дээрх хэдэн зүйлийн орчуулгын эхээс гадна “Албадууна хэлэх төрийн шастир ардыг хүчдэх дусал хэмээгдэх” (цаашид “Хүчдэх дусал” гэж товчилно) хэмээх “Рашааны дусал”-ын нэгэн бие даасан эхийг эрдэм шинжилгээний талаас хараахан дурдаагүй ажээ. Мэдээллийн хувьд “Хүчдэх дусал” нь “Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг” хэмээх их тольд бүртгэгдэн орсон боловч түүний тухай эрдэмтэд ер нь судлаагүй байсаар юм.

1. “Хүчдэх дусал”-ын ерөнхий танилцуулга

1.1. “Хүчдэх дусал”-ын хадгаламж ба хуудас хэмжээ

“Хүчдэх дусал” нь Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн номын сангийн монгол судлалын материалын тасагт хадгалагдаж буй. Хадгаламжийн дугаар нь 01132, хуудасны хэмжээ нь 8.7х32.8 см, цаасны хөвөөгөөр хар шугам татаж дотор нь хар бэхээр бичжээ. Судрын нэр ба гол агуулгыг бичсэн үсгийн тиг нь адилгүй. Наамал цаасны хоёр талд нарийхан үсэн

бийрээр бичсэн 13 хуудас дутуу судар. 13b талаас хойш дутуу. Эхний хуудсын дунд хэсэг газар нь элэгдэж цоорсноос хоёр талын үсэг нь хэсэг газар гээгджээ. Судрын зарим нүүрт үсгийн зай ба хоосон мөр үлдээж орхижээ.

Бичлэгийн дүрмийн хувьд, үгийн эхэн, дунд, адаг орох “q”, “γ”-ийг цөм ялгасангүй, адилхан дусалгүйгээр бичжээ. Үгийн эхэн дунд орох “n”-ийг зарим үгэнд дусалтай бичиж, үгийн адагт олонхдоо дусалгүйгээр бичжээ. Үгийн эхэн, дунд орох “j”, “y”-ийг ялгаагүй бичжээ. Сударт буруу үсэг ба утга нийцэхгүй өгүүлбэрүүд нэлээд бий.

Судрын нүүр бүрийн үсгийн мөрийн тоог жагсаан үзүүлбэл: 1a 26 мөр (судрын нэр багтахгүй; 9-12 дугаар мөрт үсэг дутуу бөгөөд судрын цаас цоорч хэдэн үсэг гээгджээ); 1b 28 мөр (14, 15 дугаар мөрт судрын цаас цоорч хэдэн үсэг гээгджээ); 2a 29 мөр; 2b 30 мөр; 3a 28 мөр (9, 11, 16 дугаар мөрт тус бүр нэг үсгийн зай хоосон орхиж, 12, 13 дугаар мөрийн хооронд хоёр мөр үсгийн зай хоосон орхижээ); 3b 28 мөр (17, 18, 20, 21 дүгээр мөрт тус бүр үсгийн зай үлдээж хоосон орхиж, 19-20 дугаар мөрийн хооронд хоёр мөр үсгийн зай хоосон орхив); 4a 30 мөр; 4b 30 мөр; 5a 30 мөр; 5b 29 мөр (27 ба 29 дүгээр мөрт тус бүр нэг үсгийн зай хоосон орхив); 6a 29 мөр (1, 2 дугаар мөрт тус бүр нэг үсгийн зай хоосон орхиж, 1-2 дугаар мөрийн хооронд нэг мөр үсгийн зай хоосон орхижээ); 6b 30 мөр; 7a 30 мөр; 7b 30 мөр; 8a 30 мөр; 8b 31 мөр; 9a 31 мөр; 9b 29 мөр; 10a 30 мөр; 10b 30 мөр; 11a 30 мөр; 11b 30 мөр; 12a 30 мөр; 12b 30 мөр; 13a 31 мөр; (21, 23 дугаар мөрт тус бүр нэг үсгийн зай үлдээж хоосон орхив), 13b 30 мөр. Үүнээс хойших хэсэг нь дутуу.

1.2. “Хүчдэх дусал”-ын нэр хийгээд агуулга хэлбэр

“Хүчдэх дусал”-ын агуулгыг түүний бүтцийн хувьд судрын нэр, эхлэлтийн үг жич ерөнхий агуулга гэх гурван хэсэгт хувааж болно. Ерөнхий агуулга нь “Рашааны дусал”-ын шүлгийн хэсэг ба тайлбар үлгэрийн хэсэг гэх хоёр хэсгээс бүрэлдэнэ.

1.2.1. Судрын нэрийн учир

“Албадууна хэлэх төрийн шастир ардыг хүчдэх дусал хэмээгдэх” гэдэг нь чухам тус судрын уг нэр мөн эсэх нь тодорхойгүй юм. Учир нь судрын агуулгын хэсгийг бичсэн үсгийн тиг болон судрын нэрийг бичсэн үсгийн тиг нь маш их зөрөөтэй байна.

Судрын нэрийг бичсэн үсгийн тигийн дунд орох “d”, үгийн эхэнд орох “t”, “q”, үгийн эцэст орох “n” дэвсгэр зэрэг нь судрын эхний өгүүлбэрт орсон адил үгнүүдийн бичлэгийн дэгтэй маш их зөрөөтэй байна. Судрын нэрт үгийн дунд орох “γ” ба үгийн эцэст орох “n”-ийг дусал сэргээж бичжээ. Судрын агуулгын хэсэгт эдгээрийг цөм дусалгүйгээр бичдэг юм. Эхний өгүүлбэрт “санстир” гэж байхад судрын нэрэнд “шастир” гэж бичиж буй. Судрын нэрийг бичсэн үсгийн тиг нь орчин цагийн бичлэгийн тигтэй илүү тохиролцоно. Дээрх онцлогуудаас харахад энэхүү судрын нэрийг сүүлийн хүн нэмж бичсэн болох нь тодорхой байна. Ийнхүү сүүлийн хүн нэмж бичсэн болохоор тус судрын уг нэр мөн эсэх нь мадагтай болно. Тэрчлэн энэ өгүүлбэр нь тус судрын уг нэр мөн гэж бодовч сүүлийн хүн бээр нэмж бичсэн эсхүл судрын эхний өгүүлбэрээс хуулж тавиад, нэр болгосон зэрэг хоёр зүйлийн боломж байна.

“Албадууна хэлэх төрийн шастир ардыг хүчдэх дусал хэмээгдэх” гэдэг нь тус судрын хамгийн эхний өгүүлбэр юм. Уг судрын эхлэлтийн үг нь “Албадууна хэлэх төрийн шастир ардыг хүчдэх дусал хэмээгдэх үүний нэрийн утга нь “ард” хэмээх нь ...сайн муугийн ялгалыг үл ялгах мунхгийн өвчтөнийг хүртсэн хүн бүгдийг энэ шастираар, үйл хийгээд үйл бусыг мэдэхүйд (шүтээн?) сайн амгалан бүтэж... мэт эмээр... тэжээж хэмээгднөү. ...өчүүхэн төрд... хэмээгднөү. Тэр (аль?) буюу хэмээвээс” (albadaγun-a, 1a) гэж буй. Үүнд “ард” гэж сайн муут

ялгаж чадахгүй мунхаг хүмүүс гэж томьёолжээ. Мөн бас энэ судар нь мунхаг ардыг сайн болгоход эм мэт тус болох сайн үйлдэлтэй гэх утгыг тушаажээ. “Албадууна хэлэх” гэх нь энэхүү төрийн шастирыг албаар (буюу албадаж) хэлэх ёстойг заасан байж болох юм. “Ардыг хүчдэх” гэх нь ардыг хүчтэй (буюу тамиртай) болгох хэмээх утгатай байж болно. “Төрийн шастир” ба “дусал” гэдэг бол “Ардыг тэжээхүй дусал нарт төрийн шастир” (“Рашааны дусал”)-ын ерөнхий нэртэй зохицож байгаа юм. “Хэмээгдэх үүний нэрийн утга нь” гэдэг үгнээс үзвэл “хэмээгдэх” гэгч нь ямар нэгэн нэрийг төлөөлөн зааж байгаа төлөвтэй. “Нэрийн утга нь” гэгчээс үзэхэд нэгэн нэр байсан нь тодорхой байна. Эдгээр онцлогуудаас үзвэл, “Албадууна хэлэх төрийн шастир ардыг хүчдэх дусал” гэдэг нэр нь тус судрын уг нэр байх боломж бас бий.

1.2.2. Агуулга хэлбэр

Бидэнд олдсон “Хүчдэх дусал”-ын ерөнхий агуулгын хэсэг нь нийт 13 хуудас бүхий 42 бадаг шүлгээр бүрэлджээ. Эхний 8 хуудаст нэг бадаг шүлэг бүрийн ард нэг үлгэрийн тайлбар дагалдаж, сүүлийн гурван хуудаст хоёр бадаг буюу хэдэн бадаг шүлэгт хамтад нь нэг үлгэрийн тайлбар хийжээ.

42 бадаг шүлгийн агуулга нь төвд монгол “Рашааны дусал”-ын үндсэн агуулгатай зөрөөгүй. Тайлбар үлгэр нь ч “Рашааны дусал”-ын тайлбар зохиолтой үндсэн агуулгын хувьд адил байна. Төвд, монгол “Рашааны дусал”-ын агуулгатай харьцуулж үзвэл тус судар нь “Рашааны дусал”-ын шүлгийн бадгуудыг сонголттойгоор авч найруулсан шинжтэй. 1-26 дугаар бадгийн агуулгын дараалал нь “Рашааны дусал”-ын агуулгын дараалалтай адилхан. “Рашааны дусал”-ын 1, 2 дугаар бадаг, 27-39 дүгээр бадаг жич 43, 47 дугаар бадагтай харгалзсан агуулга тус сударт орсонгүй. “Рашааны дусал”-ын 59 дүгээр бадагтай харгалзсан агуулга хүрээд хойших хэсэг нь дутуу.

“Хүчдэх дусал” нь дээр өгүүлсэн мэт хэлбэрийн хувьд шүлэг үлгэр хоёрыг хавсруулан бичсэн онцлогтой. “Рашааны дусал” бол шүлгийн хэсэг болон түүний тайлбар зохиолын хэсэг гэх хоёр хэсгээс бүрэлддэг. Монгол эрдэмт лам нарын “Рашааны дусал”-ын орчуулга нь зөвхөн шүлгийн хэсгийг орчуулсан буюу шүлэг үлгэрийн хэсгийг хамтад нь орчуулсан, жич тус тусад нь салгаж орчуулсан зэрэг гурван төрөлд хувааж болдог. Шунхан “Данжуур”-т гүүш Лувсанданзан зөвхөн шүлгийн хэсгийг нь орчуулаад үлгэрийн хэсгийг орчуулсангүй. Цахар гэвш, буриадын Д.Галсанжамба нар шүлгийн хэсэг болон үлгэрийн хэсэг хоёрыг тус тусад нь салгаж орчуулсан байдаг. Агваандампил, Номтын Ринчен, жич өгүүлэн бүхий “Хүчдэх дусал” зэрэг нь шүлгийн хэсэг болон үлгэрийн хэсгийг хамтруулан орчуулсан байна. Өөрөөр хэлбэл шүлгийн бадгуудын ард түүний тайлбар үлгэрийг дагалдуулжээ.

2. “Хүчдэх дусал” болон “Данжуур” дахь

Лувсанданзаны “Рашааны дусал”-ын харьцаа холбоо

“Хүчдэх дусал” хийгээд шунхан барын “Данжуур” дахь гүүш Лувсанданзаны “Рашааны дусал” нь хоорондоо олонх үг хэллэгийг адилхан хэрэглэсэн бөгөөд цөм толгой холбох ёсыг баримталсангүй. Орчуулгын онцлогийн хувьд хоёулаа цөм өөрчилсөн орчуулгад тооцогдоно. Тус хоёр эхээс бусад “Рашааны дусал”-ын монгол орчуулгууд нь цөм утгачилсан орчуулга болох юм. Тэрчлэн тус хоёр эхийг үг, үсэг дараалан тулгаж үзэхэд олонх шүлгийн бадгууд нь цөөн хэдэн үсэг дээр л зөрдөг. Эдгээр адил талын онцлогоос үзэхэд, энэ хоёр эх нь хоорондоо харьцаатай болох нь тодорхой байна. Зөрөөтэй үгс нь хоорондоо ойролцоо утгатай үгс байх бөгөөд бас нэлээд ондоо үгс ч бий. Зөрөөтэй талын онцлогоос үзэхэд “Хүчдэх дусал”-ыг

Лувсанданзаны орчуулгын хуулбар гэж үзэхийн аргагүй юм. Доор тус хоёр эх нь ямархан харьцаа холбоотой болохыг хоёр талаар өгүүлнэ.

2.1. “Хүчдэх дусал” бол Лувсанданзаны орчуулгад суурилан зохиогдсон гэж үзэх нь

2.1.1. Үг өгүүлбэр ойролцоо бадгуудын харьцуулал

“Хүчдэх дусал” ба Лувсанданзаны “Рашааны дусал” нь хоорондоо гагц хоёр үсгийн зөрөөтэй буюу үг үсгийн хувьд харилцан ойролцоо утгатай үгийг хэрэглэсэн жишээ олон байдаг. Гагц хоёр үсгийн зөрөөтэй бадгийн жишээ:

“Хүчдэх дусал”-д:

Бусдын гэмүүдийг үл өгүүлэгдэхүй

Бусдын гэмүүдийг өгүүлбээс

Түүнчлэн өөрт буй бөгөөд

Үлгэрлэвээс үнэг, баялгийн гэргий мэт¹

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Бусдын гэмүүдийг үл өгүүлэгдэхүй

Бусдын гэмүүдийг хэрвээ өгүүлбээс

Түүнчлэн өөрт бээр буй бөгөөд

Үлгэрлэвээс үнэг хийгээд эхнэр мэт²

Энэ хоёр бадгийн эхний мөрт үсэг зөрөхгүй. 2, 3 дугаар мөрт “хэрвээ”, “бээр” хэмээх гагц үгийн зөрөөтэй. 4 дүгээр мөрт үндсэндээ “баялгийн гэргий”, “эхнэр” гэх гагц үсгийн зөрөөтэй. Лувсанданзаны “Рашааны дусал”-д “үнэг хийгээд эхнэр мэт” гэхэд “Хүчдэх дусал”-д “үнэг, баялгийн гэргий мэт” гэсэн байна. Үүнд “эхнэр” (буюу гэргий)-ийн харьяалагдах эзэн болох “баялаг” гэх үг нэмэгдсэн байна. “Рашааны дусал”-ын бусад тайлбар үлгэрт “баялгийн гэргий” гэсэн тодотгол байдаггүй. “Хүчдэх дусал”-д “баялгийн гэргий” гэсний учир нь “Хүчдэх дусал”-ын тус бадаг дахь харгалзсан тайлбар үлгэрт “эрт Энэтхэгийн дорно зүгт нэгэн баялаг гэргий хоёул бүлгээ...” (albadayun-a, 1a) гэж “гэргий” нь тодотголтойгоор илэрдэгтэй холбогдоно.

“Рашааны дусал”-ын бусад тайлбар зохиолуудад “баялаг” гэх нэр байдаггүй бөгөөд нэн ч “баялгийн гэргий” гэж гардаггүй юм. Тус хоёр бадаг нь энэ мэт гагц хоёр үгийн зөрөөтэй байна. Гэхдээ агуулга хэлбэр, жич орчуулгын хэв намба зэрэг талаар бүр адилхан юм. Ойролцоо утгатай үгийг сольж хэрэглэсэн жишээ :

“Хүчдэх дусал”-д:

Худал үгийг үл өгүүлэгдэхүй

Худал үгийг өгүүлбээс

Үтэр бусад бээр мэдэх болъюу за

Үлгэрлэвээс мигуйн худал үг мэт³

Лувсанданзаны “Рашааны дусал”-д:

Худал үгсийг үл өгүүлэгдэхүй

Худал үгсийг өгүүлэхүй болбоос

Түргэнээ бусад бээр мэдэх болмуй

Үлгэрлэвээс мисийн худал үг мэт⁴

Тус хоёр бадагт өгүүлбээс - өгүүлэхүй болбоос, үтэр - түргэнээ, мигуй - мис гэх мэт ойролцоо утгатай гурван үгийг харилцан сольж хэрэглэснээс өөр ямар ч зөрөөгүй. Ингэж ойролцоо утгатай үгээр сольж хэрэглэсэн нь “Хүчдэх дусал”-д ямар ч утгын хувиралт үүсгэсэнгүй. Ийм маягийн гагц хоёр үг үсгийн зөрөөтэй шүлгийн бадгууд олон тоог эзэлнэ. Энэ мэт олон жишээнүүдийн суурин дээр бид “Хүчдэх дусал” нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ын суурин дээр зохиогдсон гэж үзэх бүрэн боломжтой юм.

¹ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 1a.

² Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 246a.

³ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal Өвөр Монголын Багшийн их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 4a.

⁴ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 246a.

Бид "Хүчдэх дусал" нь Лувсанданзаны "Рашааны дусал"-ын суурин дээр зохиогдсон гэдгийг баталж болох боловч эсрэгээр Лувсанданзаны "Рашааны дусал" нь "Хүчдэх дусал"-ын суурин дээр дахин боловсруулагдсан байж болох эсэхийн тухай энд бас тодорхойлж өгөх чухалтай юм. Лувсанданзаны "Рашааны дусал" нь "Хүчдэх дусал"-ын суурин дээр зохиогдсон байх боломжгүй юм.

- "Данжуур" дахь "Рашааны дусал"-ын гаргалгад гүүш Лувсанданзаны орчуулгын явцыг тодорхой нарийн тэмдэглэж байдаг. "Данжуур" дахь зохиолын гаргалга бол нэлээд найдвартай юм. Хэрвээ шинээр орчуулсан биш уулын ямар нэгэн орчуулгыг засаж хэрэглэсэн байвал тодорхойлж өгдөг зуршилтай юм. Гүүш Лувсанданзаны "Рашааны дусал"-ын гаргалгад уулын ямар нэгэн орчуулгыг ашигласан талаар юу ч дурдаагүй нь тэрээр "Хүчдэх дусал"-ын суурин дээр зохиогдсон биш гэдгийг харуулна.

- Лувсанданзаны "Рашааны дусал"-д төвд үгээс авиачлан буулгасан үгс нэлээд байдаг. Тэдгээр үгсийг "Хүчдэх дусал"-д монголжуу болгон тайлбарлахаар оролдсон нь тодорхой мэдэгдэж байна. Гэвч "Хүчдэх дусал" нь уг төвд эх нь төвд хэлний эхийг үндэслэн өөрчилсөнгүй биш юм. Энэ нь "Хүчдэх дусал" бол Лувсанданзаны "Рашааны дусал"-ын суурин дээр найруулсан гэдгийг харуулж байна.

2.1.2. Агуулгын дэс дарааллын харьцуулал

Лувсанданзаны "Рашааны дусал"-д зохиолын эхлэлтийн үг болон нэгдүгээр бадаг нь цөм мөргөлийн шүлэг болно. "Хүчдэх дусал"-д энэхүү хоёр хэсгийн агуулгыг орхигдуулав. Лувсанданзаны "Рашааны дусал"-ын хоёрдугаар бадаг нь "Хүчдэх дусал"-ын эхлэлтийн үгийн агуулгатай үндсэндээ зохицож байна. Даруй хоёрдугаар бадаг нь:

Доорд харанхуй мунхаг оюут ардад

Яруу аялгууг зул мэт тодруулахын тул

Миний мэт доодост яруу аялгууны зул үгүй боловч

Мунхгийг тэжээхүйн тул усны дуслын төдийхөн өгүүлсүгэй (albadaᠭun-a, 1a)

гэж байдаг. Лувсанданзаны "Рашааны дусал"-ын гуравдугаар бадаг нь "Хүчдэх дусал"-ын эхний бадагтай агуулга тохиролцоно. Лувсанданзаны "Рашааны дусал"-д яг энэхүү гуравдугаар бадгаас эхлээд гол агуулгадаа орно.

"Хүчдэх дусал"-ын 1-26 дугаар бадгийн агуулгын дараалал нь Лувсанданзаны "Рашааны дусал"-ын агуулгын дараалалтай адилхан. Лувсанданзаны "Рашааны дусал"-ын 27-39 дүгээр бадаг, жич 43, 47 дугаар бадагтай харгалзсан агуулга "Хүчдэх дусал"-д орсонгүй. Ийнхүү "Хүчдэх дусал" нь ер Лувсанданзаны "Рашааны дусал"-аас сонголттойгоор найруулан авсан байна. "Хүчдэх дусал"-д орсонгүй орхигдсон бадгууд нь үндсэндээ үлгэрийн агуулга (тайлбар үлгэр) байхгүй бадгууд олон байна. Бодитойгоор хэлбэл, "Хүчдэх дусал" нь Лувсанданзаны "Рашааны дусал"-д суурилан шүлгийн бадгуудыг сонгохдоо бодит үлгэр домогтой холбогдох бадгуудыг сонгон авсан байна. "Хүчдэх дусал"-д орсонгүй орхигдуулсан 12 бадаг шүлгийн жишээгээс үзэхэд, гагц бадаг нь үлгэрийн агуулгатай. Ийнхүү "Хүчдэх дусал" нь Лувсанданзаны "Рашааны дусал"-ын агуулгад суурилан найруулахдаа шүлгийн бадгуудыг үлгэрт холбогдох эсэхээр нь баримжаа болгон сонголттойгоор найруулан авсан байдаг. Дээрх онцлогуудаас ерөнхийлөн өгүүлбэл "Хүчдэх дусал" нь Лувсанданзаны орчуулгаас зохих бадгуудыг сонголттойгоор найруулж авсан эх гэж үзэж болох юм.

2.2. “Хүчдэх дусал” бол “Рашааны дусал”-ын нэгэн бие даасан эх гэж үзэх нь

“Хүчдэх дусал” бол Лувсанданзаны “Рашааны дусал”-д суурилан зохиосон нь нэлээд тодорхой гэдэг боловч тус хоёр эх нь хоорондоо зөрөөтэй тал бас цөөнгүй бий. Тэрчлэн бүрмөсөн адил бус бадгууд ч байдаг. Доор бид “Хүчдэх дусал” нь Лувсанданзаны орчуулгын авиачлан буулгасан төвд үсгийг засан өөрчилсөн, тайлбар үлгэрийн агуулгад үндэслэн зассан жич хялбар ойлгомжтой болгох хэрэгцээгээр засан өөрчилсөн зэрэг хэдэн зүйлийн үзэлтийн дагуу хоёр эхийн адил бус талыг өгүүлэх болно. Өөрөөр хэлбэл “Хүчдэх дусал” нь Лувсанданзаны орчуулгыг тэр хэвээр нь хуулсан эх биш, харин нэлээд олон талын өөрчлөлт засалт хийсэн бөгөөд бас зохих зорилттойгоор явагдсан юм.

2.2.1. Авиачлан буулгасан төвд үсгийг зассан тухай

Шунхан “Данжуур” дахь “Рашааны дусал”-ын орчуулга нь уг төвд эхээ маш нарийн баримталж бараг үсэг дараалан мөрдөж орчуулсан байдаг. Тэрчлэн зарим үг, үсгийг монгол хэлэнд орчуулсангүй тэр хэвээр нь төвд хэлнийх нь дагуу авиачлан буулгасан байдаг. “Хүчдэх дусал” нь Лувсанданзаны орчуулгын төвд хэлнээс авиачлан буулгасан үсгийг тэр хэвээр нь дагасангүй бөгөөд түүнийг олон зүйлийн арга хэлбэрээр өөрчлөн хувируулсан байдаг.

Хүчдэх дусал”-д:

Муу нөхрийг үл шүтэгдэхүй

Муу нөхрийг хэн шүтэвч

Ширхийг шүтсэнээр

Бөөсөд шантарсныг үзэгтүн⁵

Лувсанданзаны “Рашааны дусал”-д:

Муу нөхрийг үл шүтэгдэхүй

Муу нөхрийг хэн бээр шүтвээс

Агүда-г шүтсэнд

Бөөс нүгүүд гутсаныг үзэгтүн⁶

Лувсанданзаны “Рашааны дусал” дахь “агүда” гэгч бол уг төвд эхийн “na gu da” (mi rigs dpe sgrun khang, 2006 lo’i, 2.) гэдэг үгийг авиачлан буулгасан юм. “На”-гийн аймгийн дуслыг сэргээж бичсэн биш болохоор “нагүда” гэж бичсэнгүй юм. “Хүчдэх дусал”-д “нагүда”-г “ширх” гэдэг үгээр сольжээ. “Ширх” нь мөнхүү бөөс хэмээх утгатай. Энэ үг Өвөр монголын зарим нутгийн аялгуунд одоо ч гэсэн бий. Ойрад баатарлаг туульд “шилэндээ ширхэгтэй, шилбэдээ баастай” гэж гардаг. Тэр нь “Хүчдэх дусал”-ын тайлбар үлгэрийн агуулгад холбогддог. “Хүчдэх дусал”-ын тайлбар үлгэрт “бөөсний нөхөр хоёр ширх ирж, их даяанчийг идье хэмээсэнд ...” (albadaγun-a, 2b) гэж бий.

“Рашааны дусал”-ын бусад тайлбар үлгэрүүдэд “ширх” ба “нагүда” гэх үг бүр байдаггүй тэдгээрийн оронд “нохойн бөөс” гэх нэрээр илэрдэг. Ерөнхийд нь үзэхэд “Хүчдэх дусал” нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ыг тэр хэвээр нь мөрдөн дагасан биш, “нагүда” зэрэг төвд үгээс нь авиачлан буулгасан үл ойлгогдох үсгийг “Хүчдэх дусал”-д түүний тайлбар зохиол зэргээрээ баримжаа болгож засан өөрчилсөн байна.

“Хүчдэх дусал”-д:

Засдаг ёсон явдал үйл бус

Засдаг ёсон явдлыг хэн үйлдвээс

Лувсанданзаны “Рашааны дусал”-д:

Засдаг ёст явдлыг үл үйлдэхүй

Хэн засдаг ёст явдлыг үйлдвээс

⁵ albadaγun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 2b.

⁶ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 246б.

Тэр тойн болон үл хүндлэгдмүй

Тэр ариун үл болмуй

Бярман, тоть, хатан мэт⁷

На яа жал мо бярман мэт⁸

Лувсанданзаны “Рашааны дусал”-ын адаг мөрийн “на яа жал мо” гэдэг нь уг төвд эхийн “na yai rgyal mo” (mi rigs dpe sgrun khang, 2006 lo'i, 3.) гэдэг үгийг авиачлан буулгасан байна. Тус мөрт гагц “bram ze” (mi rigs dpe sgrun khang, 2006 lo'i, 3.) гэдэг үгийг монголчлон “бярман” гэжээ. “на яа жал мо барман” гэдэг нь төвд эхээс шууд авиачлан буулгасан болохоор монгол хэлэнд үл ойлгогдох үг юм. Энэхүү үл ойлгогдох үгийг “Хүчдэх дусал”-д “бярман тоть хатан” гэж өөрчилсөн байна. “Хүчдэх дусал”-ын тайлбар үлгэрийн агуулга нь бярман, тоть, хатан гурвын хооронд болсон үйл явдлыг тэмдэглэсэн болохоор уул үлгэрийн утгыг нь үндэслэн засаж хувируулсан байна. Өөрөөр хэлбэл Лувсанданзаны “Рашааны дусал”-ын “на яа жал мо” гэх үл ойлгогдох үгийг дагаж хуулбарласан биш юм.

“Хүчдэх дусал”-д:

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Мунхаг балай нэгэн заримууд нь

Зарим нэгэн буруу мунхгууд

Номын мөн чанарыг үл ухан

Номын мөн чанарыг онол үгүйеэ

Буруугаар ном үлэмж тахлагчид

Буруу номоор маш баясагчид

Мунхгууд эрдэнэ авсан мэт⁹

Тэнэгүүд чандмань авсан мэт¹⁰

Лувсанданзаны “Рашааны дусал”-ын адаг мөр дэх “чандмань” гэдэг үгийг уг төвд эхэд “nor bu” (mi rigs dpe sgrun khang, 2006 lo'i, 9.) гэсэн байна. Энэ үг нь “эрдэнэ” гэдэг утгатай. Яриангүй “чандмань” гэх орчуулга нь буруу биш. “Хүчдэх дусал”-д “чандмань” гэх үгийг монгол үг биш бөгөөд энгийн хүнд хялбар ойлгогдохгүй гэж үзээд “эрдэнэ” гэдэг үгээр сольж орчуулсан байна.

“Хүчдэх дусал”-д:

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Тийм доорд муу ардыг

Тэр мэт доорд махуа түүнийг

Дээд ордод үл удируулан тэнд үл суулгагдах

Дээд газраа үл гарган тэнд улахулагдахуй

Тэр оронд суулгавч бээр омог дээрхий

Тэр газар алхавч омгоо үл чадмуй
(дээрэнгүй, зохиогч) бээр үл чадах

Үлгэрлэвээс хөл хөх үнэг мэт буюу¹¹

Үлгэрлэвээс хөх арьст үнэг лүгээ адил¹²

“Хүчдэх дусал” ба Лувсанданзаны “Рашааны дусал”-д “хөл хөх үнэг” хийгээд “хөх арьст үнэг” гэж өөр өөр үгээр орчуулжээ. Уг төвд эх нь “pags pa sngon po' i wa” (mi rigs dpe sgrun khang, 2006 lo'i, 8) гэдэг. “pags pa” гэдэг бол төвд хэлэнд “арьс” гэх утгатай. “sngon po' i wa” гэдэг үг нь үндсэндээ “хөх үнэг” гэдэг үгтэй тохиролцоно. Лувсанданзаны “Рашааны дусал”-д уг төвд эхийг нь махчлан орчуулж “хөх арьст үнэг” гэжээ. “Хүчдэх дусал”-д Лувсанданзаны “Рашааны дусал”-ын махчилсан буюу монгол хэлэнд үл зохицох маягаар орчуулсныг засаж “хөл хөх үнэг” гэжээ. Энэ нь хөл нь хөх үнэг гэсэн үг биш харин “гүл (gülü - цул хөх. Зох.) хөх үнэг” гэсэн үг юм. “Хөл” нь “гүл”-ийн ташаа бичлэг бололтой. Өөрөөр хэлбэл “Хүчдэх дусал” нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ын махчилсан буюу монголжуу бус орчуулгыг засан өөрчилсөн нь энэ “гүл хөх” гэх үгнээс нэг хэмжээгээр ойлгогдож байгаа юм.

⁷ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 4b.

⁸ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 246b.

⁹ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 12b.

¹⁰ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 249a.

¹¹ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 11a.

¹² Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 248b.

“Хүчдэх дусал”-д:

Амьтан сайн эр эм сан хэд бээр

Үлэмж хурьцахуй тачаахуйтан эрс нь

Зүүдэнд эд олсноо

*Хууртсан мэт*¹³

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Морин хийгээд махи заан тэргүүтэн

Зарим нэгэн түүнд тачаагч нь

Хүсэлтэн ард бээр зүүдэнд

*Эдийг олоод хууртсан мэт*¹⁴

Лувсанданзаны “Рашааны дусал”-д “морин хийгээд махи заан тэргүүтэн” гэснийг “Хүчдэх дусал”-д “амьтан сайн эр эм сан хэд бээр” гэж өөрчилжээ. Уг төвд эхэд “*rta dang ma he glang bo sogs*” (*mi rigs dpe sgrun khang*, 2006 lo'i, 10) гэдэг. Энэ нь “морь болон усан үхэр, том заан тэргүүтэн” хэмээх утгатай. Лувсанданзаны “Рашааны дусал”-д “*ma he*” (усан үхэр)-ийг орчуулсангүй төвд эхээс нь “махи” гэж тэр чигээр нь авиачлан буулгасан байна. Гэвч “Хүчдэх дусал”-д “амьтан сайн эр эм сан хэд бээр” гэсэн нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ын “махи” зэрэг монгол бус үгийг ойлгомжтой болгон засах гэсэн оролдлого болно. Лувсанданзаны “Рашааны дусал”-ын “морин хийгээд махи заан тэргүүтэн, Зарим нэгэн түүнд тачаагч нь” гэдгийг Цахар гэвш:

Адгуусан морь үхэр эд идээ тэргүүтэн

Адал малд тачаалаар хэдий чинээ хураавч

Ашид эцлэлгүй орхиод үхэж одох нь

Адилтгаваас зүүдэнд хөвгүүн олоод сэрсэн мэт” (*arad-i tejiyekü rasiyan-u dusal*, 7a)

гэж орчуулжээ. Төвд хэлний уг эх буюу Лувсанданзаны “Рашааны дусал”-д энэ бадаг үгийн санаа нь мөн тодорхой биш юм. Цахар гэвшийн орчуулгыг үндэслэвэл, тус бадгийн санаа бол энэ насандаа хэдий эд хөрөнгө шунан цуглуулавч хүний бие мөнхрөхгүй болохоор тэр нь мөн л хий хоосон зүйл мөн гэсэн санаатай ажээ. Өгүүлэн буй “Хүчдэх дусал”-д уг санааг буруу ойлгосноос буруугаар орчуулсан байна. Даруй “Амьтан сайн эр эм сан хэд бээр, Үлэмж хурьцахуй тачаахуйтан эрс нь, Зүүдэнд эд олсноо, Хууртсан мэт” гэсэн нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ын нэгдүгээр мөр дэх “махи” гэдэг үгийг ойлгосонгүйгээс цааш төөрөгдсөн бөгөөд хоёрдугаар мөрийн “тачаагч” гэдэг үгийг “хурьцал тачаал”-ын утгатай хутган үзсэнээс дээрх мэт буруугаар орчуулсан бололтой.

2.2.2. Хялбар ойлгомжтой болгон зассан

“Хүчдэх дусал” нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ыг засаж өөрчлөхдөө ойлгомж муутай зарим үг өгүүлбэрийг хялбар ойлгомжтой буюу монголжуу болгож зассан байдаг. Тэдгээрийг бодит жишээгээр харуулья

“Хүчдэх дусал”-д:

Хилэнцэт нөхөр сэтгэлд зохицон

Элдэв баясгалант үг өгүүлэвч

Муу хилэнцэт тэр шимнус бөгөөд

*Үлгэрлэвээс тивийн эм мангас мэт*¹⁵

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Хилэнцэт нөхөр сэтгэл зохилдож

Элдэв баясахуй үгсийг өгүүлэвч

Муу хилэнцэт тэр шимнус бөгөөд

*Үлгэрлэвээс хойгийн эм рагш мэт*¹⁶

“Хүчдэх дусал” болон Лувсанданзаны “Рашааны дусал”-д “мангас” болон “рагш” гэдэг хоёр үгийг зөрөөтэйхэрэглэжээ. “Хүчдэх дусал” дэх “рагш” гэдэг нь монголчилсон судруудад нийтэм хэрэглэгддэг монгол хэлний “мангас”-тай тэнцэх санскрит үг юм. “Хүчдэх дусал”-д

¹³ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 12b.

¹⁴ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 248b.

¹⁵ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн Их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 8b.

¹⁶ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 247a.

“үлгэрлэвээс тивийн эм мангас мэт” гэж монгол ахуйд тохиролцуулан орчуулжээ. “Мангас” буюу “рагш” гэдэг үгийг уг төвд эхэд “sᠢᠨ mo” (mi rigs dpe sgrun khang, 2006 lo'i, 3) гэж бий. “Хүчдэх дусал” болон Лувсанданзаны “Рашааны дусал”-ын монгол орчуулга нь цөм төвд эхийг баримталсангүй. Төвд хэлэнд “sᠢᠨ mo” гэвэл эм мангасыг зааж байдаг. “Рагш” гэдэг үг нь тухайн үед монгол бичигчдийн хэрэглэж дүрэмжсэн үг бололтой. XVII зуунаас нааших монгол орчуулгын судруудад “мангас”, “рагш” хэмээх хоёр үгийг солбицуулан хэрэглэсээр ирсэн төлөвтэй. “sᠢᠨ mo” гэдэг үг төвд хэлэнд эм мангасыг заадаг бөгөөд “mo” гэдэг нь эм хүйсийг заадаг дагавар юм. Эр мангасыг төвд хэлэнд “sᠢᠨ bo” гэдэг. Д.Бүрнээ нарын найруулсан “Төвд монгол толь”-д “sᠢᠨ bo”-г “мангас, рагш” (Бүрнээ, Энхтөр, 2013:518) гэж хоёр зүйлийн нэрээр орчуулжээ. Цахар гэвшийн орчуулгад бас “рагш”-ийг “эм мангас” гэж орчуулсан байдаг. Өгүүлэн буй “Хүчдэх дусал”-д хялбар ойлгомжтой болгох, жич монгол ахуйд зохицуулах зорилтоор “рагш”-ийг “эм мангас” гэж өөрчилсөн нь тодорхой мэдэгдэж байна.

“Хүчдэх дусал”-д:

Түүний тул эрдмүүд

Амиа үрж хичээгдэхүй

Хэд бээр эрдмийг үл сурагч

*Тэр нь мунхаг адгуусан мэт*¹⁷

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Тиймийн тул эрдмүүдэд

Амин лугаа холбож хичээгдэхүй

Алимад эрдмийг үл сурагч

*Тэр нь тэнэг адгуусан мэт*¹⁸

Тус хоёр бадагт, амин лугаа холбож хичээгдэхүй - амиа үрж хичээгдэхүй, алимад эрдмийг үл сурагч - Хэд (“хэн” гэх үгийн халгуу бичлэг, зохиогч) бээр эрдмийг үл сурагч ; тэнэг адгуусан - мунхаг адгуусан гэх мэт үгсийг харилцан сольж өөрчилжээ. Энэ нь мөн хялбар ойлгомжтой болгох гэсэн санаа юм. “Алимад эрдэм” ба “Тэнэг адгуусан” гэх үг бол ер нь ойлгомж муутай үгс ажээ. Эдгээр үгсийг “Хүчдэх дусал”-д “амин лугаа үрж”, “хэд бээр”, “мунхаг” гэх мэт үгээр сольж өөрчилсөн нь орчуулагчаар өөрийнхөө ойлгосон тэрхүү байдлаар хялбарчлан зассан нь тодорхой байна.

“Хүчдэх дусал”-д:

Бүгдэд их өчүүхэн үгүй

Аран мэт тус хүргэвээс

Бүгдээр ачийг нь хариулъяу за

*Хулганын зааныг босгосон мэт*¹⁹

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Хотолд дээр доор үгүй

Аран мэт тус хүргэвээс

Хотлоор ачийг хариулмуй за

*Хулгана бээр зааныг босгосон мэт*²⁰

Тус хоёр бадагт, хотолд - бүгдэд (хотлоор - бүгдээр), дээр доор үгүй - их өчүүхэн үгүй, хулганаар зааныг босгосон мэт - хулганын зааныг босгосон мэт гэх зэргээр “Хүчдэх дусал” нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ын зарим үгийг өөрчилсөн байна. Энэ мэтээр өөрчилсөн нь хялбарчлах зорилттой байгаа нь нэлээд тодорхой байгаа юм. Лувсанданзаны “Рашааны дусал” дахь “хотол” гэх үг хийгээд “хулгана бээр” гэх үгийн “бээр” дагавар бол бичгийн хэлэнд голдуу хэрэглэх бөгөөд ардын амьд ярианы хэлэнд бараг яригдахгүй үгс юм. Үүнийг “Хүчдэх дусал”-д бичгийн хэлнээс ярианы хэлний хялбар ойлгогдох үгээр засан хувируулж байгаа нь энэ юм.

¹⁷ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн Их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 8b.

¹⁸ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 247a.

¹⁹ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн Их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 9b.

²⁰ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 247b.

2.2.3. Зөрөөтэй болсон мөр бадгууд

“Хүчдэх дусал” нь Лувсанданзаны “Рашааны дусал”-ыг зохих жам ёсны дагуу засан өөрчилсөн мөр бадгууд зонхилох тоог эзэлдэг боловч бас хоорондоо нэлээд зөрөөтэй агуулгууд байдаг юм.

“Хүчдэх дусал”-д:

Аялгуу охин өгүүлэхгүйг ас авирд

Гэр эл ухааж тийнхүү өгүүлэгдэхүй

Хэд бээр үнэн балмадаар өгүүлэгч нь

*Үлгэрлэвээс галзуугийн шастир мэт*²¹

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

Настан үгс нүгүүдийг өгүүлэн хүсвээс

Ямар шинжлэл тэр мэт өгүүлэгдэхүй

Алимад шинжлэл үгүйеэ өгүүлсэн нь

*Үлгэрлэвээс галзуусын шастир мэт бий*²²

“Үлгэрлэвээс галзуугийн шастир мэт” гэх нэг мөрөөс бусад нь бүр адилгүй. Энд ямар баримжаагаар өөрчилсөн буюу тэр нь зөв эсэх тухай өгүүлэхгүй. Бидэнд тодорхой харагдаж байгаа нь тус бадгийн өмнө гурван мөр нь агуулга хэлбэр, хэв загварын хувьд иххэн зөрөөтэй байна.

“Хүчдэх дусал”-д:

Сайн ёсон үгүй дээдхий(дээрэнгүй, зохиогч)

Арга зальгүй мэт гэж балмад

Хянаад найдангүй доромжлогч ичгүүр

*Хөвгүүн болбоос бээр тэвчигдэхүй*²³

Лувсанданзаны “Рашааны дусал”-д

*Дээдсийн ёсон үгүй бардмаар маш
маш их их омогт*

*Арга зальт сүсэг үгүй хэрээ мэт дэмий
хэллэгч хянан донгодон*

*Засдаг атаархах хурьцал хийгээд үгүй
тийм хүн шагшаабадүгүй ичгүүр үгүй*

*Тийм хүн хөвгүүн болбоос бусад мэт
машид тэвчигдэхүй*²⁴

Тус хоёр бадагт дөрөвдүгээр мөрөөс бусад мөрийн агуулга нь хоорондоо огт адилгүй. Дөрөвдүгээр мөрийн үндсэн агуулга нь ойролцоо боловч өгүүлбэрийн загвар болон орчуулгын хэв намба нь ондоо ондоо байдаг. Иймэрхүү маягийн харилцан зөрөөтэй бадгууд нэлээд хэд бий. Харьцуулан буй хоёр эхийн энэ мэт зөрөө нь бидэнд “Хүчдэх дусал” бол Лувсанданзаны “Рашааны дусал”-ын шууд хуулбар биш гэдгийг нэг хэмжээнд батлан өгч байгаа билээ.

Дүгнэлт

“Хүчдэх дусал” бол шунхан “Данжуур” дахь Лувсанданзаны орчуулсан “Рашааны дусал”-ыг үндэслэж найруулсан эх болно. Гэхдээ түүний шууд хуулбар биш харин нэг хэмжээгээр засан найруулсан эх юм. Бодитойгоор хэлбэл, хялбар ойлгомжтой бөгөөд монголжуу маягийн болгох жич зарим төвд эхээс нь авиачлан буулгасан үгсийг тайлбар үлгэрийн агуулгад үндэслэн засах зэрэг нэлээд олон талын өөрчлөлт хийсэн гэдэг нь уг хоёр эхийн харьцууллаас тодорхой харагдаж буй. Тийнхүү “Хүчдэх дусал”-ыг “Рашааны дусал”-ын монгол орчуулгын нэгэн бие даасан эх гэж үзэх нь зүй ёстой ажээ. Буриадын Цүүгэл дацанд модон бараар хэвлүүлсэн Д.Галсанжамбын “Рашааны дусал” нь Цахар гэвшийн орчуулгад нэлээд хэдэн зүйлийн засалт өөрчлөлт хийж найруулсан эх юм. Үүнийг бид Д.Галсанжамбын бие даасан орчуулгын эх гэж үзэж байгаа билээ. Мөн бас буриадын Номтын Ринчений “Эрдэнийн хумх” хэмээх нэр бүхий

²¹ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн Их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 3а-3б.

²² Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 246а.

²³ albadayun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн Их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж, 6б.

²⁴ Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014, 249а.

“Рашааны дусал” (шүлгийн хэсэг) нь Д.Галсанжамбын орчуулгын эхэд бага хэмжээний засалт хийж хэвлүүлсэн байдаг. Үүнийг бид мөн Номтын Ринчений бие даасан орчуулгын эх гэж үзэж буй. Учир нь эдгээр эхүүд нь өөрийн тодорхой жам хууль болон тогтсон үзэл чиглэлийн дагуу засан өөрчлөгдсөнд оршино. Ийнхүү “Хүчдэх дусал”-ыг ч бид мөн энэхүү баримжааны дагуу “Рашааны дусал”-ын бие даасан орчуулгын эхэд тоочих ёстой гэж үзэж байна.

Номзүй

Бүрнээ Д., Энхтөр Д. *Төвд-Монгол толь*. Уб., 2013.

Рашааны дуслын монгол төвд тайлбар. Ц.Дамдинсүрэн эмхэтгэн найруулав. Уб., 1964.

albadaγun-a kelekü törü-yin šastir arad-i küčidekü dusal. Өвөр Монголын Багшийн Их сургуулийн номын сангийн 01132 тоот хадгаламж.

arad-i tejiyekü rasiyan-u dusal kemekü šastir orusibai. (Цахар гэвшийн орчуулга), Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн 1143 дугаарт хадгаламж.

Данжуур, 211 боть. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2014.

skye bo gso thigs. mi rigs dpe sgrun khang. 2006.